



ШҮҮХИЙН ТАМГЫН ГАЗАР

2013 оны Санхүүгийн Тайлан

Төв аймгийн Аудитын газар нь Төрийн Аудитын тухай хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд орон нутгийн төсвөөс санхүүждэг төсөвт байгууллагын санхүүгийн тайланд нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, холбогдох хууль, журам зааварт нийцүүлэн аудит хийж байна.

Лавлах зүйл байвал 70272248
дугаарын утаснаас лавлана уу?

Л.Жаргалсайхан
Аймгийн Ерөнхий аудитор
өрөөний утас 70272582
Аудитын менежер
Т.Майцэцэг
Аудитор
Ц.Саранчимэг

өрөөний утас 70273204

Аймгийн Аудитын газар
Төрийн байгууллагын ордон

Аудитыг дуусгавар болгосон тухай тайлан

АГУУЛГА

ХУУДАС

• Аудит хийж дууссан тухай мэдэгдэл	2-3
• Танилцуулга	4
• Санхүүгийн дотоод хяналт	5
• Гол шийдлүүд	6
• Тайлбар мэдүүлгийн захидал.....	7
• Аудитын санал дүгнэлт	7

**Шүүхийн Тамгын хэлтсийн 2013 оны Санхүүгийн Тайланд
аймгийн Аудитын газар аудит хийж дууссан тухай мэдэгдэл**

Бид Шүүхийн Тамгын хэлтсийн 2013 оны Санхүүгийн тайланд аудитаа хийж бараг дуусаж байгаа ба Шүүхийн Тамгын хэлтсийн Ерөнхий менежерт энэхүү аудит хийж дуусгах тухай мэдэгдлийг өргөн барьж улмаар энэхүү санхүүгийн тайланг дахин шалган нягталж бидэнд туслахыг хүсч байна. Удирдлагын захидал хэмээх тусдаа хэсэгт санхүүгийн хяналтыг сайжруулах талаархи бидний өгсөн зөвлөмжүүд орсон бөгөөд Шүүхийн Тамгын хэлтэс нь тухайн зөвлөмж бүрд хариу явуулна уу.

Удирлагын зөвлөлийн анхаарлыг дараах зүйлд чиглүүлж байна:

Гол санхүүгийн хяналтууд хамрагдсаныг тодруулбал:

- Орлого санхүүжилт, бараа ажил үйлчилгээний урсгал зардал, цалингийн зардал, бараа материал, үндсэн хөрөнгө авлага, мөнгөн хөрөнгө, өглөг бусад асуудлуудыг хамруулсан бөгөөд байж болзошгүй эрсдлийг тооцож холбогдох батламж мэдэгдлүүд хэрхэн хангагдаж байгааг нотлох үүднээс холбогдох стандарт, журам зааврын дагуу шаардлагатай горимыг хэрэгжүүлсэн.

Гол илрүүлсэн зүйлс буюу аудитын үр дүнгээс гарсныг тодруулбал:

1. Шүүх өөрчлөн байгуулагдаж өөр ажил албан тушаалд шилжин томилогдсонтой холбогдуулан цаашид үргэлжүүлэн ажиллаж байгаа 48 ажилтанд 20445.8 мянган төгрөгийн цалин олгосон.
2. Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын тушаалаар 3 шүүгчид 35.0 сая төгрөгний орон сууцны дэмжлэг гэж олгосноос татвар 3500.0 мянган төгрөгийг суутган шилжүүлээгүй байна.
3. Мөн 5 ажилтанд 5.0 сая төгрөгийг амьдрал, ахуй байдлыг дэмжих зорилгоор нэг удаагийн буцалтгүй тусламж олгохдоо Засгийн газрын 2004 оны 112 тоот тогтоолын 5-д заасан сарын цалингаас хэтрүүлэн 3239.0 мянган төгрөг илүү олгосон байна.
4. Батлагдсан төсөвт тусгагдаагүй зардал гарган сургалт семинарын сургагч багш болон бусад ажлаар ирсэн албан томилолтоор ажиллаж байгаа дээд газрын хүмүүсийг 822.4 мянган төгрөгөөр хооллосон, Төрийн алба болон гүйцэтгэж байгаа ажил үүрэгтэй холбогдолгүй 122.8 мянган төгрөгийн сонин хэвлэлийг захиалсан, Эмэгтэйчүүдийн баярт 132.5 мянган төгрөгийг зарцуулж нийт 1077.7 мянган төгрөгийг үргүй зарцуулсан байна.

Ерөнхий менежерээс аймгийн Аудитын газарт тайлбар мэдүүлэг хүлээж байгаа илэрсэн алдааг хэрхэн залруулсан талаар тайлбар ирүүлнэ үү.

Аудитыг дуусгаж аудитын явцад олж авсан ажлын баримтанд үндэслэн дээрх дурьдагдсан алдаа зөрчилд төлбөрийн акт бичигдсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргахаар Ерөнхий аудиторт санал оруулсан байгаа

Ерөнхий Аудитор 2014 оны 2-р сарын 23-ны өдөр санал дүгнэлтэнд гарын үсэг зурна.

Төв Аймгийн Аудитын Газар

Танилцуулга

1. Бид Шүүхийн Тамгын хэлтсийн 2013 оны 12 дугаар сарын 31-р тасалбар болсон санхүүгийн тайланд аудитаа хийж бараг дуусаж байгаа ба Шүүхийн Тамгын газрын даргад энэхүү аудит хийж дуусгах тухай мэдэгдлийг өргөн барьж улмаар энэхүү санхүүгийн тайланг дахин шалган нягталж бидэнд туслахыг хүсч байна. Удирдлагын захидал хэмээх тусдаа хэсэгт санхүүгийн хяналтыг сайжруулах талаарх бидний өгсөн зөвлөмжүүд орсон бөгөөд Шүүхийн Тамгын газар нь тухайн зөвлөмж бүрд хариу явуулна уу.
2. Бидний 2013 оны тайланд хийсэн аудит нь 2 гол элементтэй:
 - Санхүүгийн хяналтын системийг дахин шалгах
 - Жилийн санхүүгийн тайланд аудит хийх

Аудитаас үүдэн гарсан асуудлууд дараах хэсэгт хураангуйлагдсан.

Жилийн санхүүгийн тайланд аудит хийх

Аймгийн Аудитын газар жилийн санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг баталгаажуулах шаардлагатайг авч үзсэн. Бидний дахин шалгалтын үр дүнд цаг ямагт үр өгөөжтэй материаллаг алдаанаас сэргийлж чадах гол санхүүгийн хяналтыг онцгойлон үзсэн юм.

Дараахь түвшний хяналтын асуудал бидний дахин шалгалтын үр дүнгээс гарсан бөгөөд үүнд Шүүхийн Тамгын газрын удирдлагын анхаарлыг хандуулж байна:

1. Санхүүгийн дотоод хяналтын талаар

Шүүхийн Тамгын хэлтсийн даргын 2013 оны 07- дугаар сарын 09-ний өдрийн 39 тоот тушаалаар Дотоод хяналтын зөвлөл байгуулах тухай шийдвэр гарч 5 ажилтны бүрдэлдэхүүнтэй зөвлөл байгуулагдсан байна. Дотоод хяналт шалгалтыг төсвийн хөрөнгийг зүй зохистой, үр ашигтай зарцуулах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглүүлэх, өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, ашиглалтанд хяналт тавьж, зөрчлийг арилгах хяналт шалгалтын үр дүнг удирдлагад танилцуулж байхад чиглэсэн байна. 2013 онд зөвлөл байгуулагдаж хяналт шалгалт хийгдсэн байна.

2. Орлого, санхүүжилтийн талаар

Төсвийн сар, улирлын хуваарийг үзэж, хуваарийн дагуу санхүүжилтээ авсан эсэхийг Шүүхийн тамгын газрын баримтанд шалгахад Шүүхийн ерөнхий зөвлөлөөс оны эхний 5 сарын төсвийг 254865.3 мянган төгрөгөөр баталсныг өөрчлөн нэмж 5 сард 649194.4 мянган төгрөг, 2013 оны 10-р сарын 11 өдрийн тогтоолоор 4-р улирлын зарим урсгал зардлын төсөв 59067.1 мянган төгрөг, 2013 оны 12-р сарын 16-ны өдрийн 39 тоот тогтоолоор төсвийн багцын 12 сарын хуваарийг шинэчлэн батлахад нэмж 32261.8 мянган төгрөгийн санхүүжилт нийт 740523.3 мянган төгрөгийн төсөв батлагдсан төсвийн хуваарь ирсэн байна. Шүүхийн Тамгын хэлтсийн орлогын төлөвлөгөө батлагдаагүй бөгөөд 2013 онд тодорхойлолтын орлого 668.2 мянган төгрөгний үндсэн бус үйл ажиллагааны орлого оруулсан байна.

3. Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 953862.1 мянган төгрөг, тайлант онд 167115.2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө нэмэгдэж, оны эцэст 1120977.3 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Төрийн өмчийн хорооноос үндсэн хөрөнгө худалдан авах зөвшөөрөл өгсний дагуу 18259.1 мянган төгрөгийн тавилга эд хогшил худалдан авсан, Шүүхийн ерөнхий

зөвлөлөөс эвлэрүүлэн зуучлалд 1734.4 мянган төгрөгийн тавилга эд хогшил үнэгүй ирснийг орлогоор бүртгэж авсан байна.

Тоног төхөөрөмжийн дансанд Шүүхийн ерөнхий зөвлөлийн шийдвэрээр Иргэн-1 программд 15845.4 мянган төгрөг, эвлэрүүлэн зуучлалын тоног төхөөрөмж 1153.5 мянган төгрөг, Захиргааны хэргийн шүүхэд 1031.3 мянган төгрөг, нээлттэй шүүхийн хуралдааны танхимд 52541.5 мянган төгрөгийн тоног төхөөрөмж ирснийг орлогоор бүртгэж авсан байна.

Шүүхийн ерөнхий зөвлөлөөс Санхүүгийн тооцоолох ХХК-ны санхүүгийн программыг 550.0 мянган төгрөгөөр ирснийг орлого авсан байна.

4.Бараа материал

2013 оны эхэнд бараа материалын данс нь 13415.9 мянган төгрөгийн үлдэгдэлтэй 43478.4 мянган төгрөгийн бараа материал орлого авч, 36476.5 мянган төгрөгийн бараа материал зарлагдаж оны эцэст 20417.7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан байна. Өмнөх оноос бараа материалын дансны худалдан авалт 19622.9 мянган төгрөгөөр, зарлага 15215.4 мянган төгрөгөөр, оны эцсийн үлдэгдэл 7001.9 мянган төгрөгөөр өссөн байна. Бараа материалын дансны эцсийн үлдэгдэлийг дэд дансаар өмнөх оны үлдэгдэлтэй харьцуулахад бичиг хэрэг 5387.0 мянган төгрөг, бусад хангамжийн материал 2286.0 мянган төгрөгөөр өссөн бөгөөд аж ахуйн бараа материал 557.0 мянган төгрөг, сэлбэг хэрэгсэл 81.9 мянган төгрөг, шатахуун 196.1 мянган төгрөгөөр тус тус буурсан байна. Бараа материалын орлогын гүйлгээг харилцах данснаас шилжүүлсэн тохиолдолд авлага өглөгийн дансаар дамжуулан бүртгэсэн байна. Бараа материал дансанд хөглөгдөх анхан шатны баримтын бүрдлийг хэсэгчлэн шалгахад тайлан гаргалт, баримт бүрдүүлэлт орлого, зарлагын баримт, шаардах хуудас зэргийг зохих журмын дагуу холбогдох албан тушаалтан гарын үсэг тамга тэмдэг дарагдсан шаардлагын түвшинд хангалттай сайн байна.

Шатахуун зарцуулалтанд байгууллагаас Аймгийн шүүх, ЗХШүүх, Тамгын хэлтэс, СД-1 шүүх, СД-2 шүүх гэсэн хэрэглэгчдээр лимит тогтоож зарцуулалтанд хяналт тавьж ажилласан байна. Энэхүү тогтоосон лимитийн дагуу шатахуун зарцуулалтыг шалгахад шүүн таслах үйл ажиллагаанд нийт шатахуун зарцуулалтын 38.0 хувь буюу 6547.6 мянган төгрөг, бусад аж ахуйн ажилд 62.0 хувь буюу 17026.7 мянган төгрөгийн шатахуун зарцуулсан байна. Шатахуун зарцуулалтын тооцоог жолооч нэг бүрээр тооцоог бодож зөрүүг тухай бүрд нь төсвийн шууд захирагч болон аймгийн Ерөнхий шүүгчид танилцуулж ажилласан байна.

5.Цалингийн талаар

2013 онд нийт 44 орон тоо батлагдаж, гүйцэтгэлээр 44 орон тоогоор ажиллажээ. Цалингийн сан 535109.6 мянган төгрөг батлагдсанаас 572225.5 мянган төгрөгний зардал гарч батлагдсан төсвийг 37115.9 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан байна. Шүүхийн ерөнхий зөвлөлөөс 2013.12.25-ны өдрийн 03/1536 тоот албан бичгээр аймгийн Шүүхийн Тамгын газарт төсвийн хуваарийг хүргүүлж оны эцэст 32 261.8 мянган төгрөгний санхүүжилт нэмж олгосон байна.

Энэ санхүүжилтээс дээрх албан бичигт заасны дагуу Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 23.2-т заагдсан "Тухайн шүүгчийн цалингийн хэмжээ шүүгчээр ажилласан тав дахь жилээс эхлэн жил бүр өмнөх оныхоос хоёр хувиар нэмэгдэж байна." гэсний дагуу 2013 оны 12 дугаар сард уг нэмэгдэлд шүүгч нарт 12 966.2 мянган төгрөгийг олгосон байна. Үүнээс гадна Шүүхийн Тамгын газрын даргын 2013.12.26-ний өдрийн 15 тоот тушаалаар Шүүх байгуулах тухай хуулийн 1. 2 дахь хэсэгт зааснаар өөрчлөн байгуулагдаж өөр ажил албан тушаалд шилжин томилогдсонтой холбогдуулан тухайн албан тушаалын цалингийн хувиар ажилтнуудад цалинг олгох шийдвэр гаргаж 48 ажилтанд 20 445 888 төгрөгийг цаашид үргэлжүүлэн ажиллаж байгаа нийт ажилтнуудад олгосон зөрчил илэрлээ.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын 2013 оны 08 дугаар сарын 02 –ны өдрийн 14 дугаар тушаалаар Төв аймгийн Шүүхийн шүүгч 3 хүнд нийт 35.0 сая төгрөгний орон сууцны дэмжлэг гэж олгосноос ХХОАТатвар 3500.0 мянган төгрөгийг суутган шилжүүлээгүй байна.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын 2013 оны 04 дугаар сарын 11 ний шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын 31 тоот захирамжаар 2 ажилтанд 2.0 сая төгрөг, 2013 оны 08 дугаар сарын 02 –ны өдрийн 13 дугаар тушаалаар 3 ажилтанд 3.0 сая төгрөг нийт 5.0 сая төгрөгийг амьдрал, ахуй байдлыг дэмжих зорилгоор нэг удаагийн буцалтгүй тусламж олгосон нь Засгийн газрын 2004 оны 112 тоот тогтоолын 5-д албан хаагчийн өрхийн орлого буурч, нэг гишүүнд ногдох хэмжээ нь амьжиргааны баталгаажих доод түвшинд хүрэхгүй болсон тохиолдолд гэр бүлийг нь дэмжихэд зориулан тухайн албан хаагчийн 1 сарын албан тушаалын цалингаас нь хэтрүүлэхгүйгээр жилд нэг удаа буцалтгүй тусламж олгоно гэснийг зөрчиж сарын цалингаас хэтрүүлэн 3239.0 мянган төгрөг илүү олгосон байна.

6.Бараа үйлчилгээний зардал

Дулаан, цэвэр бохир усны үнийг Төв Чандмань ДЭХГ-т, цахилгааны үнийг Зуунмод ЭХСалбарт, телефон утасны ярианы төлбөрийг Холбооны газар, шуудан хүргэлт болон бичиг хэргийн материалыг ШҮГЗарт нэхэмжлэхийн дагуу шилжүүлсэн. Шатахууныг МТ Төв ХХК-аас гэрээ хийж, нэхэмжлэхийн дагуу авч мөнгийг шилжүүлж байна.

Батлагдсан төсөвт тусгагдаагүй зардал гарган сургалт семинарын сургагч багш болон бусад ажлаар ирсэн албан томилолтоор ажиллаж байгаа дээд газрын хүмүүсийг төсвийн мөнгөөр хооллож зардлыг төлбөр хураамж болон сургалт семинарын зардлаас нийт 822.4 мянган төгрөгийг зарцуулсан байна

Төрийн мэдээлэл болон хууль зүйн мэдээлэлээс гадна хэвлэл захиалгын үнэ 122.8 мянган төгрөгийн зардал гаргасан нь Төрийн алба болон гүйцэтгэж байгаа ажил үүрэгтэй холбогдолгүй /нам, олон нийтийн байгууллагын/ сонин хэвлэлийг захиалсан, Эмэгтэйчүүдийн баярт 132.5 мянган төгрөгийг зарцуулж төсвийг үргүй зарцуулсан байна.

7.Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн оны эцэст үлдэгдэл 73.3 мянган төгрөгөөр тайлагнасан байна.

Мөнгөн гүйлгээний тайлангаар 839021.9 мянган төгрөгийн орлого 838948.6 мянган төгрөгийн зарлага гарсан байна.

Засгийн газрын 2012 оны 205 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 7.11-д тухайн байгууллагын данснаас дараахь тохиолдолд орлого бууруулах гүйлгээ хийхийг зөвшөөрнө гэсэн заалтын дагуу нийгмийн даатгалын сангаас даатгуулагчтай холбоотой даатгалын төлбөр, татварын буцаан олголт, андуурагдсан гүйлгээний нийт 15856.5 мянган төгрөгийн зарлагыг орлого бууруулах бичилт хийж тайлагнасан байна.

Мөнгөн хөрөнгийн гүйлгээ болон харилцахын үлдэгдэл ерөнхий дэвтэр, журнал, СТ-д үнэн зөв тусгагдсан байна.

Оны эцэст төсвийн тухай хуулийн 7.7-д Энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ. гэсэн заалтын дагуу үлдэгдэл 4641.4 мянган төгрөгийг төвлөрүүлснийг “Төрийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 7.11-д тухайн байгууллагын данснаас дараахь тохиолдолд орлого бууруулах гүйлгээ хийхийг зөвшөөрнө гэсэн заалтыг мөрдөлгүйгээр төсвийн гүйцэтгэлийн тайлангийн зардалд төвлөрүүлэх шилжүүлэгээр тайлагнасан байна. Энэ нь Шүүхийн ерөнхий зөвлөлийн нэгтгэл дээрээ цэвэрлэгдэх бичилт хийгдэж тайлагнагдах учир зардалд оруулж тайлагнасан байна.

Бэлэн мөнгө гаргахдаа албан томилолт 6109,7 мянган төгрөг, иргэдийн төлөөлөгч нарын цагийн хөлс 2543.9 мянган төгрөг, хамтын сангийн хуримтлал 1543.7 мянган төгрөг, шүүхийн ажилтны холбооны суутгал болон бусад суутгал зэрэгт 954.0 мянган төгрөгийг бэлнээр гаргаж төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журмын 6.3-д ... банкны харилцах дансгүй этгээдийн төлбөрийг бэлэн мөнгөөр гүйцэтгэх ... гэсэн заалтыг мөрдөж ажиллаагүй харилцах данстай өөрийн ажиллагсдын болон иргэдийн төлөөлөгчийн холбогдох зардлыг бэлнээр гаргасан байна.

8. Авлага, өглөгийн талаар

НДХэлтэстэй хийсэн байгуулсан шимтгэлийн тооцоо 115185.8 мянган төгрөг, Татварын хэлтэст 48773.8 мянган төгрөгийн татварын тооцоо үүссэнийг өр авлагын журналыг мөнгөн гүйлгээний журналтай тулган баталгаажуулахад НДШимтгэлийн тооцоо зөрүүгүй тохирч байна. Мөнгөн гүйлгээний журналаар 49155.4 мянган төгрөгийн татвар төлсөн, НДТайлангаар 48843.9 мянган төгрөг байгаа нь төлсөн татвар 311.5 мянган төгрөгөөр илүү, өглөгийн тайлангаар байгуулсан татварын өглөг 48773.8 мянган төгрөг, НДТайлангаар 48965.0 мянган төгрөг 191.2 мянган төгрөгөөр дутуу байна. Бусад байгууллага хоорондын авлага болон өр төлбөрүүдийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан байна.

Аудитын явцад хийгдсэн гол шийдлүүд

5. Дараах хэсэгт Санхүүгийн тайлангийн аудитын явцад гарсан гол асуудлуудыг хураангуйлан тэмдэглэсэн.

- ✓ Батлагдсан төсвийн дагуу үр ашигтай аривлан хэмнэлттэй зарцуулах
- ✓ 35.0 сая төгрөгний орон сууцны дэмжлэг гэж олгосноос татвар 3500.0 мянган төгрөгийг суутган шилжүүлээгүй, Батлагдсан төсөвт тусгагдаагүй зардал гарган 822.4 мянган төгрөгөөр хооллосон, Төрийн алба болон гүйцэтгэж байгаа ажил үүрэгтэй холбогдолгүй 122.8 мянган төгрөгийн сонин хэвлэлийг захиалсан, Эмэгтэйчүүдийн баярт 132.5 мянган төгрөгийг зарцуулж нийт 4577.7 мянган төгрөгийг үргүй зарцуулсныг төлүүлэх
- ✓ Шүүх өөрчлөн байгуулагдаж өөр ажил албан тушаалд шилжин томилогдсонтой холбогдуулан цаашид үргэлжүүлэн ажиллаж байгаа 48 ажилтанд 20445.8 мянган төгрөгийн цалинг 2013.12.29-нд олгосон асуудлыг Шүүхийн ерөнхий зөвлөлийн багцад аудит хийгдэж буй багт уламжилж асуудлыг шийдвэрлүүлэх

Бидний илрүүлсэн зүйлс болон дээрх санхүүгийн дотоод хяналтын талаар санал нь удирдлагын захидалд тусгагдсан байна. Санхүүгийн гүйлгээнүүд нь хүлээн зөвшөөрхүйц зохицуулагдсаныг тэмдэглэсэн.

Залруулагдаагүй алдаа

Аудитын стандарт нь аудитын явцад илэрсэн тодорхой биш болон залруулагдаагүй алдаанд анхаарал тавихыг шаарддаг. Эдгээр залруулагдаагүй алдаанууд байгууллагын удирдлагын анхаарлын төвд хүргэгдэх болно.

Тайлбар мэдүүлгийн захидал

Аудитын үйл явцад аймгийн Аудитын газар хөндлөнгийн шинжээчийн хувьд удирдлагын зүгээс гаргасан баталгаанд тулгуурлах ёстой байсан ч хараат бус байдлын хувьд энэ батламжийг дагах нь зохистой байсангүй. Аудитын гүйцэтгэл бүрд /тайлбар мэдүүлгийн захидлаар/ санхүү бүртгэлийн даргаас эдгээр батлагааг бичгээр баталгаажуулан олж авахыг хүсч байна.

Өмнөх зөвлөмжийн биелэлт

2012 оны санхүүгийн тайлангийн аудитаар 3 зөвлөмж өгөгдсөнийг хэрэгжүүлж ажилласан байна

1. Байгууллагын зардлын гүйцэтгэлийг бодитой бус тайлагнах нь төлөвлөгөөг хийх, хянах, батлах, шинжилгээ судалгааны дүнд нөлөөлөх учир төсвийн гүйцэтгэлийн тайланг үнэн зөв тайлагнах
2. Сарын цалингаас хэтэрсэн цалингийн урьдчилгаа олгохгүй байх
3. Өмч, хөрөнгийн хохиролтой холбоотойгоор Өмч хамгаалах байнгын комисс нь хэлэлцэхдээ комиссийн акт, дүгнэлт гаргаж түүний дагуу даргын тушаалаар асуудлыг шийдвэрлэж байх

Шүүхийн Тамгын газрын дарга албан тоотоор биелэлтийг гаргаж ирүүлсэн байна.

Аудитын санал дүгнэлт

Аймгийн Аудитын газраас тус тайланд материаллагын урьдчилан тогтоосон түвшингээс бага байгаа тул **Зөрчилгүй санал дүгнэлт** гаргахаар санал оруулж байна.

Аймгийн Аудитын газар